



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/345

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолоор баталсан татан буулгах комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтаар баталсан “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-ыг татан буулгахтай холбоотой зардлыг санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

2.Татан буулгах комиссын өр, төлбөр барагдуулах дараалал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор үйлдвэрийн газрын он дамжсан өр, авлагыг барагдуулах, дуусгалтын тайлан гаргах ажлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулах, зарцуулалтыг тайлагнаж ажиллахыг “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ (Ж.Бодьгэрэл)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР